

МОНГОЛ УЛС  
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2021 оны 06 сарын 14 өдөр

Дугаар А/382

Номгон


Гамшгаас хамгаалах бүх нийтийн бэлэн байдлын  
зэрэгт хэсэгчлэн шилжүүлсэнтэй холбогдуулан  
авах зарим арга хэмжээний тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.7, 10.9.2, 32 дугаар зүйлийн 32.1.1, аймгийн Засаг даргын 2021 оны А/342, А/381 дүгээр захирамж, аймгийн Онцгой комиссын 2021 оны 50 дугаар хуралдааны тэмдэглэлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Коронавируст халдварын батлагдсан тохиолдлууд өсөн нэмэгдэж байгаатай холбогдуулан иргэд, олон нийтийнхээ эрүүл, аюулгүй байдлыг хангах зорилгоор 2021 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн 08:00 цагаас 2021 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн 24:00 хүртэл хугацаанд Улаанбаатар хот болон бусад аймгуудаас иргэд хүлээн авахыг зогсоож, зөвхөн буян ном, эрүүл мэнд, хүнс, шатахуун, эм, эмнэлгийн хэрэгсэл, бараа, барилгын материалын ачаа тээвэр, уул уурхайн ээлж солилцохыг зөвшөөрч, бусад тохиолдолд аймгийн Онцгой комиссын зөвшөөрлийг үндэслэн нэвтрүүлэх;

2.Дээрх хугацаанд аймаг доторх зорчигч, тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг бүрэн зогсоож, дээрх шалтгаанаас бусад тохиолдолд тухайн сумын Онцгой комиссын зөвшөөрлөөр нэвтрүүлэхийг Цагдаагийн газар (цагдаагийн хурандаа Б.Оюутболд), сумдын Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Онцгой байдлын газар (Онцгой комиссын орлогч дарга, хурандаа Ж.Алтангэрэл)-т даалгасугай.



Д.МӨНХСАЙХАН

621010963